Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр

Биеийн тамир, спортын газрын Бодлого төлөвлөлтийн албаны Ахлах арга зүйч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: -Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн газар хэлтэс -Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллага, спортын холбоод -Иргэн хуулийн этгээд
--	---

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийн ахлагч, Бодлого төлөвлөлтийн албаны Ахлах арга зүйч	Байгууллагын нэр:
Д.Чулуунцэцэг	Биеийн тамир спортын газар

20....оны ... дүгээр сарын ...-ны өдөр	<u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u> ДАРГА / Б.ОЮУНБААТАР / 2023 оны-р сарын өдөр	

Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны дугаар сарын-ны өдрийн
.....дугаар тушаалын хорин наймдугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ ✓ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаал тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2023.10.12

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар

Нэгжийн нэр:

Аж ахуйн алба

Албан тушаалын нэр:

Нягтлан бодогч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээ, ТҮ-8

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Баянхонгор аймаг Баянхонгор сумын Рашаант 10-р баг.
Биеийн тамир, спортын газар

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох хуулиудын заалтыг хэрэгжүүлж байгууллагын үндсэн чиг үүрэг зорилтыг ханган биелүүлэх талаар гаргасан Төр, засгийн тогтоол шийдвэрийг биелүүлж, нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын ажлыг гүйцэтгэх, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавих. Байгууллагын нийт ажиллагсдын ажиллах нөхцөл, баталгааг хангах, санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулах, материаллаг баазыг бэхжүүлэх, иргэд аж ахуйн нэгж байгууллагад үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг бодитой төлөвлөх болон төсвийн санхүүжилтийг цаг

хугацаанд бүрэн төвлөрүүлэх, хянах, хөрөнгийг үр ашиг хэмнэлттэй зарцуулах. Санхүүгийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн бодлого, баримт бичгийг боловсруулах. Шилэн дансны хуулийг мөрдлөг болгон ажиллах

Албан тушаалын зорилт:

1. Байгууллагын үнэт цаас, үндсэн хөрөнгө, бараа материал, орлого, авлага, өглөгийн тооцоог хугацаанд нь хийн эд хариуцагчийн тооцоо, ажилтан албан хаагчдын цалин хөлс, НДШ, татварыг тодорхойлон НД болон татварын байгууллагуудтай тооцоо хийх
2. Байгууллагын ил тод байдлын хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах үүднээс шилэн данс, мэдээллийн самбарт санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь байршуулах
3. Байгууллагын санхүүгийн байдал үр дүнг НББООУС-ийн дагуу тайлагнаж, үйл ажиллагаатай холбогдсон мэдээлэл боловсруулах, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах.
4. Байгууллагын эзэмшлийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангах.
5. Төсвийн төсөл боловсруулах
6. Санхүүгийн баримт материалыг цэгцэлж архив хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэж өгөх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г, Хянах -Х, Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Сар бүрийн эцэст төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ гаргах, удирдлагыг мэдээллээр хангах, ажиллагсдын цалинг сар бүрийн 25-ны дотор бодож баталгаажуулах	Байгууллагын үнэт цаас, үндсэн хөрөнгө, бараа материал, орлого, авлага, өглөгийн тооцоог хугацаанд нь хийн эд хариуцагчийн тооцоо, ажиллагсдын цалин хөлс, НДШ, татварыг тодорхойлон НД болон татварын байгууллагуудтай тооцоо хийх.	Г,Х
	2.Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалийн тооцоог дараа сарын 05 -нд хийх, мэдээллэх		Г,Т
	3.Нийгмийн даатгалын мэдээ, тайланг гаргаж дараа сарын 3 -ны дотор холбогдох байгууллагатай тооцоо нийлж актаар баталгаажуулах.		Г,Т
	4.ХАОАТ -ын тайланг улирал бүрийн 20 -ны дотор гаргаж, тооцоо нийлж үлдэгдлийг актаар баталгаажуулан сар бүрийн 25 -ны дотор шилжүүлнэ.		
2 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын шилэн дансны хуулийг мөрдлөг болгон мэдээ мэдээллийг оруулах	Шилэн дансны мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан байна.	Г,Т

	2.Байгууллагын санхүүгийн мэдээллийн самбарт төсөв санхүүгийн мэдээллийг тогтмол байршуулах, албан хаагчдыг төсөв санхүүгийн холбогдох хууль тогтоомжийн мэдээллээр хангасан байх	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г,Т
	3.Байгууллагын төсөв санхүүгийн мэдээллийг сар улирлаар хамт олны хуралд тайлагнах, мэдээллэх	Мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.	Г,Т
	4.ХНУМС-ээс албан хаагчдын цалингийн мэдээллийг татан цалин, нэмэгдэл хөлсийг тооцох, олгох	Албан хаагчдын мэдээлэл баталгаажсан байна.	Г,Т
3 дугаар зорилтын хүрээнд	1.Төсөв санхүүтэй холбоотой ажил арга хэмжээг жил, улирал, сараар төлөвлөж, төлөвлөгөөний биелэлтийг ханган байгууллагын удирдлагад тайлагнах	Гүйцэтгэлийн чанар үр дүн хангагдсан байна.	Г,Т
	2.Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг санхүүгийн батлагдсан төсвийн хүрээнд ханган ажиллах	Төсөв санхүүгийн сахилга батыг хангасан байна.	Г,Х
	3.Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримт бичиг боловсруулж мөрдөх.	Байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааны чанар сайжирсан байна.	Г,Т
	4.Байгууллагын санхүү аж ахуйн үйл ажиллагаанд сар бүр дүгнэлт өгч, зардлыг хэмнэх талаар саналаа танилцуулан удирдлагыг мэдээллээр ханган хамтран ажиллах.		
	5.Байгууллагын мөнгөн хөрөнгийн урсгалд хяналт тавих, орлого зарлагын гүйлгээг шуурхай гүйцэтгэх		
	6.Жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн аудитын шалгалт хийлгэж баталгаажуулан хангалттай үнэлэгдсэн байх, тайлан мэдээг цаг хугацаанд нь холбогдох байгууллагад өгөх.		
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Байгууллагын өмч, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтанд хяналт тавьж, хагас бүтэн жилийн өмч хөрөнгийн тооллогыг зохион байгуулах байгууллагын эд хөрөнгө, автомашин техник	Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын чанар сайжирсан байна.	Г,Х

	хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх зорилгоор тухайн зардлыг төсөвт тусган хэрэгжүүлэх.		
	2.Байгууллагат улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр баригдаж буй барилга байшин бусад хөрөнгө оруулалтад хяналт тавих, удирдлагыг мэдээллээр ханган ажиллах	Хөрөнгө оруулалтын чанар хүртээмж нэмэгдэж, зарцуулалт	
5 дугаар зорилтын хүрээнд	2.Байгууллагын нэгж, зөвлөл, комисс, ажлын хэсгийн ахлагч, дарга, гишүүдийг төсөв санхүүгийн мэдээллээр хангаж, чадавхжуулах ажлыг зохион байгуулах	Төсөв санхүүгийн мэдээллээр хангагдсан байна.	Г,Т
	3.Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор байгуулагдсан нэгж, зөвлөл, комисс, ажлын хэсгүүдийн чиг үүргийг тодорхойлох, хяналт тавих	Чиг үүргийн хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х
	1.Байгууллагын дараагийн жилийн төсвийн төслийг хугацаанд нь бодитой, үндэслэлтэй, чанартай боловсруулан холбогдох дээд шатны байгууллагад өргөн барьж батлуулах.	Төсөв санхүүгийн тооцоолол үндэслэлтэй, хууль тогтоомжид нийцсэн байна.	Г,Т
	2.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, гүйцэтгэл үр дүнг тооцуулах, дүгнүүлэх	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна.	Г
	3.Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, албан бичгийн стандартыг мөрдөн чиг үүргийн дагуу байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримтуудаар хадгаламжийн нэгж бүрдүүлж архивд шилжүүлэх;	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Г
	4.Олон улсын стандарт ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцооны шаардлагыг хэрэгжүүлэх;	Олон Улсын стандартад нийцүүлэн ажилласан байна.	Г

5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	Хууль, тогтоомжид заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г
6.Байгууллагын даргын тушаалаар аливаа нэг ажлын хэсэг, зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллахаар бол холбогдох журмын дагуу ажиллах	Журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
7.Цаг үеийн шинжтэй, нийтийг хамарсан болон олон нийтийн арга хэмжээ, бусад ажлуудад идэвхтэй оролцох, шинэ санал, санаачилга гарган хэрэгжүүлэх, өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлийн чиглэлээр сургалтанд хамрагдах.	Албан хаагчийн сахилга хариуцлага сайжирсан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол		Бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
Мэргэжил		Нягтлан бодох бүртгэл /0411/, Санхүү банк даатгал /0412/, Эдийн засаг /0311/,
Мэргэшил		Мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтанд хамрагдсан
Туршлага		Төрийн албанд 4-өөс доошгүй жил мэргэжлээрээ, ажилласан байх
	Дүн шинжилгээ	- Судалгааны арга зүй, мэдлэгтэй байх - Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх - Мэдээллийг нэгтгэж, санал зөвлөмж боловсруулах - Ажлын гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг тайлагнах - Бусад
	Асуудал шийдвэрлэх	- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх - бүтээлч санаачилагч, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх - хуулийн эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх - бүтээлч, санаачлагатай ажиллах -бусад
	Багаар ажиллах	-өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах -багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх -багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах -мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах -хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - Багийн зохион байгуулагчтай хамтран ажиллах -Бусад
	Манлайлах	-ёс зүйн хэм, хэмжээг сахиж, зарчимч, тууштай ажил

		хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэх -шинэлэг санаа, шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих -ажил хэргийн хувьд бүтээлч санаачилгатай ажиллах -байгууллагын үйл ажиллагаанд шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх
	Бусад	-өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх -ашиг сонирхлын зөрчлөөс ангид шударга байх -зарчимч тууштай, ажил хэрэгч байх -албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх -компьютерийн хэрэглээний текстэн, хүснэгтэн, үзүүлэн бэлтгэх программ болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх -төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх -англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх -бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх -хэлтсийн үйл ажиллагааг зохион байгуулж, албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавих. -монгол бичгээр унших, бичих чадвартай байх

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Биеийн тамир, спортын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: -Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн газар хэлтэс -Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллага, спортын холбоод -Иргэн хуулийн этгээд
---	---

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u> <u>Албан тушаал:</u> Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийн ахлагч, Бодлого төлөвлөлтийн албаны Ахлах арга зүйч Д.Чулуунцэцэг 20... оны ... дүгээр сарын ...-ны өдөр	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> <u>Байгууллагын нэр:</u> <u>Биеийн тамир спортын газар</u> <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

ДАРГА

/ Б.ОЮУНБААТАР /

20... оны дугаар сарын ..-ны өдөр

Биеийн тамир,спортын газрын даргын
2023 оны дугаар сарын..... өдрийн
.....хорин долоодугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаал тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2023.10.12

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар

Нэгжийн нэр:

Аж ахуйн алба

Албан тушаалын нэр:

Аж ахуйн албаны зохион байгуулагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮСБ-3

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Баянхонгор аймаг Баянхонгор сумын Рашаант 10-р баг.
Биеийн тамир, спортын газар

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго: Байгууллагын эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний зорилтод нийцүүлэн өдөр тутмын үйлчилгээ, аж ахуйн шинжтэй ажлуудыг

зохион байгуулах, үйл ажиллагааны хэрэгжилтэнд оролцох, хяналт тавих, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь шуурхай биелүүлэх, байгууллагын эд хөрөнгийн бүрэн байдалд хяналт тавьж ажиллах

Албан тушаалын зорилт: 1.Аж ахуйн алба нь байгууллагын үйл ажиллагааг стратеги зорилтын хүрээнд байгууллагын төсөв санхүүгийн бодлогыг

тодорхойлох, төлөвлөх, хуулийн хүрээнд зарцуулах, хяналт тавих, байгууллагын нийт ажиллагсдын ажиллах нөхцөл, баталгааг хангах, санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулах, материаллаг баазыг бэхжүүлэх, иргэд аж ахуйн нэгж байгууллагад үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг бодитой төлөвлөх болон төсвийн санхүүжилтийг цаг хугацаанд бүрэн төвлөрүүлэх, хянах, хөрөнгийг үр ашиг хэмнэлттэй зарцуулах. Санхүүгийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн бодлого, баримт бичгийг боловсруулах. Шилэн дансны хуулийг мөрдлөг болгон ажиллах

2.Сургалт, дасгалжуулалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах бүх нөхцлийг бүрдүүлж, барилга байгууламж, эзэмшил газрын бүрэн бүтэн байдал, түүний харуул хамгаалалт, цахилгаан, дулаан, цэвэр бохир усны хангамж, түүний инженерийн шугам сүлжээ, гадна дотно орчны цэвэрлэгээ, үйлчилгээ, аюулгүй байдал, өрөө тасалгаа, танхим, ажилчдын өрөөний эд хогшил, техник хэрэгсэл тоног төхөөрөмжийн хангамж, тэдгээрийн засвар үйлчилгээ, аюулгүй байдал, цэвэрлэгээ, тохижилтын ажлуудыг гүйцэтгэхэд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах.

3.Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг архив албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавар, журам, архивын тухай хуулийн дагуу эрхлэн гүйцэтгэх, байгууллагад ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдол бүртгэх, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавих, байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах

5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г, Хянах -Х, Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Байгууллагын өдөр тутмын үйлчилгээ, аж ахуйн шинжтэй ажлуудыг зохион байгуулахад хяналт тавих, арга зүйгээр хангах	Байгууллагын үйл ажиллагааг сайжирна	Х,Г,Ш
	2.Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүү, татварын бүх төрлийн тайлан гаргаж удирдлагад болон харилцагч байгууллагуудад хүргүүлж, хугацаанд нь тайлагнах, санхүүгийн бүртгэлийг хууль журам, стандартын дагуу үнэн зөв хөтлөн явуулах, байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих, нягтлан, няравын ажлыг санхүүгийн нэгдсэн удирдлагаар ханган, хяналт	Санхүү бүртгэлийг хууль журам, стандарт хангагдана	Х,Г,Т

	тавьж, зохион байгуулан ажиллах		
	3.Спорт заалаар үйлчлүүлэх иргэд, байгууллага, аж ахуй нэгжүүдийн түрээс, түрээсийн гэрээ байгуулах, түрээсийн гэрээний биелэлт,болон түрээсийн төлбөр төлөлтийн биелэлтийг хариуцан ажиллах	Гэрээний биелэлт хангагдана	Г,Х
	4.Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг судлах, удирдлагад танилцуулах	Тоног төхөөрөмжийн хангалт сайжирна	Г,Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалтад ашиглалтанд хяналт тавин бүртгэлтэй машин техникийг үзлэг үйлчилгээнд хамруулахад хяналт тавих	Эд хөрөнгийн ашиглалт сайжирна	Г,Х
	2.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, захиргаа аж ахуйн ажлын үр дүнг дээшлүүлэх,	Байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилт хангагдана	Г, Х
	3.Байгууллагын ажлын байрны их болон урсгал засвар хийлгэх, цахилгаан, халаалтын найдвартай ажиллагаа, өвлийн бэлтгэл хангах ажлыг графикын дагуу батлуулж ажиллах	Байгууллагын орчин сайжирна	Х,Г
	4.Өөрийн ажил үүрэгтэй холбоотой статистик тоон мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд байрлуулах, удирдлагыг мэдээллээр хангах,	Суурь судалгаатай болсон байна.	Х,Г
	5.Байгууллагын годно дотно цэвэрлэгээ,тохижилт, үйлчилгээний чанарт хяналт тавих, удирдлагаар хангах	Тохижилт, үйлчилгээний чанарт ахиц гарсан байна	Г
	6.Галын аюул гарах, дулаан, цэвэр бохир усны шугам, цахилгаан хангамж тасалдах, элдэв халдлага, хулгай зэрэг зөрчил, доголдол гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан	Аюулгүй байдал хангагдана	Г

	үед байгууллагын удирдлага, холбодох газар, хүмүүст яаралтай мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг авах		
	7.Байгууллагын эд хөрөнгийн байдлыг сайжруулах төлөвлөгөөг боловсруулах хяналт тавих, засвар үйлчилгээ, дулаан, цахилгаан, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна	Г,Т
	8.Байгууллагыг гэнэтийн аваар ослоос сэргийлж ажиллах, холбогдох үзлэг шалгалтуудыг тогтоосон хуваариар тогтмол явуулах,	Аливаа эрсдлээс урьдчилан сэргийлсэн байна.	Г,Т
3 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагаас харилцагч байгууллагуудад гарж буй албан бичгийн хүргэлтийг хариуцан, бүртгэлийн дэвтэр хөтлөх	Хугацаатай болон явуулсан бичгийн шийдвэрлэлт сайжирна.	Г,Х
	2.Албаны ажилчдын өдөр тутмын ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хянах, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах	Үйл ажиллагаа сайжирна	Х,Г
	3.Архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөх, ажилчдыг арга зүйгээр хангах, хяналт тавих.	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангаж, ажилчдын мэдлэг сайжирсан байна.	Х,Г,Т
	4.Байгууллагад ирсэн явсан бичгийн бүртгэл, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих	ирсэн явсан бичгийн бүртгэл, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Х,Г
	5.Байгууллага, албаны үйл ажиллагаанд ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцооны шаардлагыг биелүүлж ажиллах	Ажлын байрын орчин нөхцөл сайжирсан байна.	Г,Т
	6.Засгийн газар, агентлаг, орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллагууд, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах	Салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирсан байна.	Г,Т

	7.Агентлаг бусад холбогдох дээд шатны байгууллагад чиг үүрэгтэй холбоотой мэдээ тайлан, судалгааг хугацаанд нь чанартай шуурхай гаргах, хүргүүлэх	Бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, чанарт ахиц гарсан байна.	Х,Г
	8.Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, албан бичгийн стандартыг мөрдөн албаны чиг үүргийн дагуу байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримтуудаар хадгаламжийн нэгж бүрдүүлж архивд шилжүүлэх;	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Х,Г
	9.Нэгжээс гаргаж байгаа бодлогын баримт бичгийн боловсруулалт, тайлагналт хэрэгжилтэд хяналт тавих, удирдлагаар ханган ажиллах	Мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэл үр дүн, үр нөлөө сайжирсан байна.	Х,Г
	10.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангах, гүйцэтгэл үр дүнг тооцох	Нэгжийн чиг үүргийн гүйцэтгэл, үр дүн сайжирсан байна.	Х,Г
	11.Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилтийг удирдлага арга зүйгээр ханган, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцон үнэлж, байгууллагын даргад үнэлгээний саналыг хүргүүлэх	Нэгжийн мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэл, үр дүн сайжирсан байна.	Г,Х
	12.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	Хууль, тогтоомжид заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г,Х
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол		Бакалавр түүнээс дээш боловсролтой байх	
Мэргэжил		Нягтлан бодох бүртгэл,татвар /0411/, Нягтлан бодох бүртгэл /041101/,Санхүү банк, даатгал /0412/, Багш, мэргэжлийн /0114/, Менежмент ба удирдахуй /0413/,Эрх зүй /042/,	
Мэргэшил		Мэргэшүүлэх багц сургалт болон мэргэжлийн нарийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх.	
Туршлага		Төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-Биеийн тамир,спортын салбарын бодлого, төлөвлөлтийг тодорхойлох. -Хариуцсан албаны үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, шаардлага	

		тавьж чаддаг байх. -Албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдан зохион байгуулах -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, чиг үүргээр ханган ажиллах. -Байгууллага, сумдын биеийн тамир, спортын талаарх үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих, удирдлагаар хангах -Бусад
	Дүн шинжилгээ	-Биеийн тамир, спортын салбарын асуудлаар судалгаа хийх, зөвлөмж санал боловсруулах, хяналт шинжилгээ хийх арга зүйн мэдлэгтэй байх. -Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх -Мэдээллийг нэгтгэж, санал зөвлөмж боловсруулах -Ажлын гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг тайлагнах -Бусад
	Асуудал шийдвэрлэх	-Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах -өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх -бүтээлч санаачилагч, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх -төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих -ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх -хуулийн эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх -бүтээлч, санаачлагатай ажиллах -бусад
	Багаар ажиллах	-өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах -багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх -багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах -мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах -хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - Багийн зохион байгуулагчтай хамтран ажиллах -Бусад
	Манлайлах	-ёс зүйн хэм, хэмжээг сахиж, зарчимч, тууштай ажил хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэх -шинэлэг санаа, шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих -ажил хэргийн хувьд бүтээлч санаачилгатай ажиллах -байгууллагын үйл ажиллагаанд шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх
	Бусад	-өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг

		байх -ашиг сонирхлын зөрчлөөс ангид шударга байх -зарчимч тууштай, ажил хэрэгч байх -албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх -компьютерийн хэрэглээний текстэн, хүснэгтэн, үзүүлэн бэлтгэх программ болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх -төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх -англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх -бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх -албаны үйл ажиллагааг зохион байгуулж, албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавих. -монгол бичгээр унших, бичих чадвартай байх
--	--	---

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Биеийн тамир спортын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Нягтлан бодогч-1

Нярав-1

Жолооч -1

Үйлчлэгч-10

Жижүүр-4

Цахилгаанчин-1

Сантенхикч -1

Бусад харилцах субъект:

-Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн газар хэлтэс

-Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллага, спортын холбоод

-Иргэн хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u> <u>Албан тушаал:</u> Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийн ахлагч, Бодлого төлөвлөлтийн албаны Ахлах арга зүйч / Д.Чулуунцэцэг/ 20... оны ... дүгээр сарын ...-ны өдөр	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> <u>Байгууллагын нэр:</u> Биеийн тамир спортын газар <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

ДАРГА / Б.ОЮУНБААТАР /
20..... оны дугаар сарын ..-ны өдөр

Биеийн тамир,спортын газрын даргын
20... оны ... дугаар сарын ... - ны өдрийн
... тоот тушаалын наймдугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаал тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2023.10.12

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар

Нэгжийн нэр:

Бодлого төлөвлөлтийн алба

Албан тушаалын нэр:

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Албан тушаалын цалин:

Төрийн үйлчилгээ, ТҮ-5

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Баянхонгор аймаг Баянхонгор сумын Рашаант 10-р баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавар, журам, архивын тухай хуулийн дагуу эрхлэн гүйцэтгэх, өргөдөл гомдол бүртгэх, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавих, байгууллагын дотоод сүлжээ, албан хэрэг хөтлөлтийн программ, цахим системийг хариуцах, байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, даргын өмнө ажил үүргээ хариуцах

Албан тушаалын зорилт:

1. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу хөтлөн явуулах
2. Байгууллагын архивын өрөөг стандартын дагуу тохижуулах, зориулалтын дагуу ашиглах, үйлчлэх, архивын үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам заавар, стандартын дагуу хөтлөн явуулах
3. Байгууллагад иргэд, аж ахуйн нэгж, үйлчлүүлэгч, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч танилцуулах, хуулийн дагуу шийдвэрлүүлэх,
4. Даргын өдөр тутмын ажлын зохион байгуулалтыг хангаж, тав тухтай ажиллах орчин, нөхцлийг бүрдүүлэх
5. Байгууллагын дотоод сүлжээ, архив албан хэрэг хөтлөлтийн цахим систем, программыг ашиглах, хариуцан ажиллах, мэдээ тайланг цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллах
6. Бусад эрхлэх ажил үүрэг

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г, Хянах -Х, Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгууллагын ирсэн, явсан бичгийг бүртгэх, хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн стандарт сайжирсан байна.	Г,Х
	2.Хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног, улирал, хагас бүтэн жилээр тайлагнаж удирдлагыг мэдээллээр хангах		Г,Т
	3.Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр гарсан дүрэм, журмын дагуу баримт бичиг зохион бүрдүүлэх, байгууллагын хэмжээнд мөрдүүлэх. Байгууллагын албан хаагчдад албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын хэрэгжилтийн асуудлаар арга зүйгээр хангаж ажиллах, сургалт явуулах		Г,Т
	4.Хэвлэмэл хуудасны захиалга, ашиглалт, зарцуулалтыг бүртгэж, хяналт тавих, зарцуулалтын тайлан		

	мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж тайлагнах		
2 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталгаажуулан архивт баримт хүлээж авах хуваарь, төлөвлөгөө гаргаж, ажилтнуудаас хугацаанд нь акт бүртгэлээр хүлээн авах	Дараа оны 1-р улиралд багтаан архивын баримтыг бүрдүүлсэн байна.	Г,Т
	2.Ажилтнуудад үүсч хөтлөгдсөн бүх төрлийн баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх. /Цаасан суурьт болон кино гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэг, цахим, шинжлэх ухаан зураг төслийн баримт/	Архивын нөхөн бүрдүүлэлт хийгдсэн байна.	Г,Т
	3.Байгууллагын тухайн онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж байгууллагын дэргэдэх ББНШК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулах, хурлын үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэрийг хангуулж, баримтжуулах	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлагдсан байна.	Г,Т
	4.Архивын хэрэг буюу хадгаламжийн нэгж бүрдүүлэлтээр байгууллагын албан хаагчдыг арга зүйгээр хангах, ажлын байран дээр болон мэргэжлийн байгууллагатай хамтарч сургалт зохион байгуулах	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.	Г
	5.Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах, архивын баримтын хадгалалт, хамгаалалт, эрэлт хайлт, ашиглалтын үйл ажиллагааг сайжруулах,	Архивын баримтын хадгалалт хамгаалалт сайжирсан байна.	Г

	түргэн шуурхай болгох		
3 дугаар зорилтын хүрээнд	1.Өргөдөл, гомдол, хүсэлт гаргасан иргэд, үйлчлүүлэгч, албан хаагчдийг холбогдох албан тушаалтантай холбох, шуурхай шийдвэрлүүлэхэд чиглүүлж өгөх	Чиг үүргийн хэрэгжилт хангагдсан байна.	Г,Т
	2.Байгууллагат ирсэн иргэдийн өргөдөл, гомдол санал хүсэлтийг бүртгэх, удирдлагад танилцуулж, холбогдох албан тушаалтанд шилжүүлэх, шийдвэрлэлтийн байдалд тухай бүр хяналт тавих	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт хугацаандаа хийгдсэн байна.	Г,Х
	3.Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал, хагас, бүтэн жилээр холбогдох байгууллагат хүргүүлэх, хамт олны хурал, удирдлагад танилцуулж, санал гаргах	Удирдлага, ажилтнуудад өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээллээр хангагдсан байна.	Г,Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Даргад танилцуулагдах албан бичиг, тушаал шийдвэрийг цаг алдалгүй танилцуулж шийдвэрлүүлэх, уулзалт, хурал, зөвлөгөөнд оролцох цагийг зохицуулах, бэлтгэлийг хангах.	Ажлын чиг үүргийн хариуцлага, зохион байгуулалт сайжирсан байна.	Г,Т
	2.Даргын ажилтнуудын хоорондын ажлын уялдаа холбоо, харилцааг шуурхай зохицуулах	Удирдлагыг мэдээллээр ханган ажилласан байна.	Г
	3.Даргад гадаад, дотоодын байгууллага, иргэдийг хүлээн авах уулзалтын цагийг зохицуулах, хүлээн авах цагийг товлох, баталгаажуулж зар хүргэх, бэлтгэлийг хангах	Захирлын ажлын цагийн төлөвлөлт сайжирсан байна.	Г,Т
	4.Даргыын албан өрөө тасалгаанд цэвэрлэгээ үйлчилгээ хийлгэх, бичгийн хэрэгсэл, цайны болон	Өрөө танхимын тохилог орчин бүрдсэн байна.	Г

	шаардлагатай материалыг захиалан бэлтгүүлэх, уулзалтын үед цай, кофегоор үйлчлэх		
5 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын дотоод сүлжээгээр холбогдох мэдээ, мэдээллийг хүргэх, таницуулах	Мэдээллийн шуурхай байдал хангагдсан байна.	Г
	2.Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн ERP программыг хариуцаж, ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэн удирдлагад танилцуулан холбогдох албан хаагчдад шилжүүлж, албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хаалтад хяналт тавих, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах	ERP програмын ашиглалт, хөтлөлт сайжирсан байна.	Г,Т
6 дугаар зорилтын хүрээнд	1.Архив бичиг хэргийн ажилтны ажлын төлөвлөгөөг улирал, хагас, бүтэн жилээр боловсруулж батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах	Төсөв санхүүгийн тооцоолол үндэслэлтэй, хууль тогтоомжид нийцсэн байна.	Г,Т
	2.Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна.	Г
	3.Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, албан бичгийн стандартыг мөрдөн чиг үүргийн дагуу байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримтуудаар хадгаламжийн нэгж бүрдүүлж архивд шилжүүлэх;	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Г
	4.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай сайн биелүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг тогтмол тайлагнах	Ажлын гүйцэтгэл үр дүн сайжирсан байна.	Г

	5.Ажлын цагийг чанд баримталж, үйлчилгээг үзүүлэхдээ ажилтан албан хаагчид, иргэдийг ялгаварлахгүй хандах, ёс зүйн зөрчил, хүнд сурталгүй үйлчлэх	Ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Г
	6.Цаг үеийн шинжтэй, нийтийг хамарсан болон олон нийтийн арга хэмжээ, бусад ажлуудад идэвхтэй оролцох, шинэ санал, санаачилга гарган хэрэгжүүлэх, өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлийн чиглэлээр сургалтанд хамрагдах.	Албан хаагчийн сахилга хариуцлага сайжирсан байна.	Г
	7.Байгууллагын үйлчилгээ, иргэд болон харилцагч төрийн болон төрийн бус байгууллагатай харилцаа, хамтын ажиллагаа, захидал харилцааны асуудлыг хариуцан ажиллах	Иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын харилцаа, хамтын ажиллагаа сайжирсан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол		Бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
Мэргэжил		Архив судлал 032202, эрх зүй 0421
Мэргэшил		Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх
Туршлага		Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх
	Дүн шинжилгээ	- Судалгааны арга зүй, мэдлэгтэй байх - Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх - Мэдээллийг нэгтгэж, санал зөвлөмж боловсруулах - Ажлын гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг тайлагнах - Бусад
	Асуудал шийдвэрлэх	- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх - бүтээлч санаачилагч, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх - хуулийн эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх

		чадвартай байх - бүтээлч, санаачлагатай ажиллах -бусад
	Багаар ажиллах	-өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах -багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх -багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах -мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах -хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - Багийн зохион байгуулагчтай хамтран ажиллах -Бусад
	Манлайлах	-ёс зүйн хэм, хэмжээг сахиж, зарчимч, тууштай ажил хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэх -шинэлэг санаа, шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих -ажил хэргийн хувьд бүтээлч санаачилгатай ажиллах -байгууллагын үйл ажиллагаанд шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх
	Бусад	-өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх -ашиг сонирхлын зөрчлөөс ангид шударга байх -зарчимч тууштай, ажил хэрэгч байх -албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх -компьютерийн хэрэглээний текстэн, хүснэгтэн, үзүүлэн бэлтгэх программ болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх -төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх -англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх -бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх -хэлтсийн үйл ажиллагааг зохион байгуулж, албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавих. -монгол бичгээр унших, бичих чадвартай байх
IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ		
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:		

Биеийн тамир, спортын газар	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Туслах, үйлчилгээний ажилтнууд	Бусад харилцах субъект: - Багш, дасгалжуулагч нар -Бусад ажилчид -Төрийн болон төрийн бус байгууллагууд, спортын холбоод -Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u> Албан тушаал: Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийн ахлагч, Бодлого төлөвлөлтийн албаны Ахлах арга зүйч Д.Чулуунцэцэг 20... оны ... дүгээр сарын ...-ны өдөр	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> <u>Байгууллагын нэр:</u> Биеийн тамир, спортын газар <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> Биеийн тамир, спортын газар <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>	
ДАРГА	/Б.ОЮУНБААТАР/
20... оны дугаар сарын ..-ны өдөр	

Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны сарын ны өдрийн
..... дүгээр тушаалын хорин есдүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ ✓ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаал тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2023.10.12

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Биеийн тамир, спортын газар

Нэгжийн нэр:

Аж ахуйн алба

Албан тушаалын нэр:

Нярав

Албан тушаалын цалин:

Төрийн үйлчилгээ, ТҮ-3

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Баянхонгор аймаг Баянхонгор сум, Рашаант 10-р баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго: Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад ашиглалтыг сайжруулах, хяналт тавих, ажилтан албан хаагчдын эд хөрөнгө бусад холбогдох материалыг тасралтгүй хангах, байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, баримтын хадгалалт, хамгаалалтыг хангах, хариуцаж авсан хөрөнгийн тоо ширхэгийг бүртгэх, албан хаагч нэг бүртэй эд хөрөнгийн карт хөтлөх, нягтлан бодогчид анхан шатны баримтын бүрдэлт, тайлан мэдээг гаргаж өгөх, барилга барих, засвар үйлчилгээ хийхэд хяналт тавих, удирдлагын өмнө ажлаа

хариуцах			
Албан тушаалын зорилт:			
1.Байгууллагын барилга байшин, багийн заалууд, гадаа биеийн тамирын талбайнууд, цэнгэлдэх хүрээлэн, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг сайжруулах хяналт тавих, санал дүгнэлт дэвшүүлэх			
2.Байгууллага доторх үндсэн болон эргэлтийн хөрөнгө, багийн заалнуудын эд хөрөнгө, техник тоног төхөөрөмж, оффис өрөө танхимын эд хогшил, техник хэрэгслын ашиглалт хадгалалт хамгаалалтыг сайжруулах, хяналт тавих, албан хаагчдын эд хөрөнгө болон бусад холбогдох материалаар тасралтгүй хангах үйл ажиллагааг явуулах, хүлээлцэх			
3.Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн бүртгэлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу хөтлөх, тайлагнах, өмч хамгааллын зөвлөлтэй хамтран өмч хөрөнгийн тооллого явуулах мэргэжил арга зүйгээр хангах, албан хаагчид удирдлагыг мэдээллээр хангах, өмч хамгаалалтай холбоотой тайлан мэдээг холбогдох газарт тайлагнах			
4.Байгууллагатай хамтран ажиллаж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, түрээслэгчидтэй гэрээ байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, орлого бүрдүүлэлтийг хянах, нягтлан бодогчид орлого зарлагын тооцоог мэдээллэх, холбогдох баримт бичгийг бүрдүүлэх, зарцуулалтыг удирдлага, хамт олонд улирал тутам тайлагнах			
5.Байгууллагын туслах ажилтануудын ажил үйлчилгээ, багийн заал зохион байгуулагчдийн орлого бүрдүүлэлт бусад үйл ажиллагаанд хяналт тавих, санал дэвшүүлэх			
6.Бусад эрхлэх ажил үүргийг хэрэгжүүлэх			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г, Хянах -Х, Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгууллагын барилга байшин, багийн заалууд, гадаа биеийн тамирын талбайнууд, цэнгэлдэх хүрээлэнгийн эд хөрөнгө, тоног төхөөрөмж, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хариуцах, бүртгэлжүүлэх, тооллогод хамруулах, хяналт тавих	Хагас бүтэн жилээр өмч хөрөнгийн тооллого хийж, үр дүнг удирдлагад танилцуулсан байна.	Г,Х
	2.Барилга байшин, багийн заал, гадаа талбайн судалгаа гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх, баяжилт хийх	Мэдээллийн санд жил бүр шинэчлэлт хийж, засвар үйлчилгээ хийсэн тухай мэдээллийн санд бүрдүүлэн ажилласан байна.	Г,Т
	3.Барилга байшин, багийн заал, цэнгэлдэх хүрээлэнг ашиглаж, хамгаалж буй ажилтнуудад мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих, гадна ногоон байгууламж, тохижилт үйлчилгээг сайжруулах	Өмчийн ашиглалт, хамгаалалт сайжирч, ногоон байгууламж байгуулсан байна.	Г,Т

	1.Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн анхан шатны бүртгэлийг тухай бүр хөтөлж, тайланг улирал бүрийн дараа сарын 05- ны дотор гаргах	Тайлант хугацаанд мэдээг захирал, нягтлан бодогчид танилцуулж, хянуулсан байна.	Г
	2.Ажилтнуудын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн маягтын дагуу хөтлөх	Ажилтан нэг бүрт эд хөрөнгийн карт хөтлөгдсөн байна.	Г
	3. Эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах , эд материал болон үндсэн хөрөнгийн хөдөлгөөнд тухай бүрд нь өөрчлөлт хөдөлгөөн хийж бүртгэх.	Өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалт сайжирсан байна.	Г,Т
	4. Албан хаагч нарт цэвэрлэгээ үйлчилгээ, бичиг хэргийн материалыг батлагдсан нормоор, удирдлага болон нягтлан бодогчийн зөвшөөрсөн тоо хэмжээгээр баримтын дагуу олгох, хяналт тавих	Ажилтан албан хаагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байна.	Г
	5.Ажилтан албан хаагчдын нэр дээр картлагдсан эд хогшлын хөдөлгөөнийг картаар тухай бүр хийх	Ажлаас чөлөөлөгдөх, шинээр ажилд орж буй албан хаагчдад эд хөрөнгийн бүртгэл хийсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын өмч хамгаалах зөвлөлтэй хамтран өмч хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, тайлагнах, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах	Өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалт, хадгалалт сайжирсан байна.	Г,Т
	2.Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилд 2 удаа хийж удирдлагаар тайланг хянуулах, холбогдох газарт тайлан мэдээг хүргүүлэх	Хагас бүтэн жилээр байгууллагын тооллогы тайлан мэдээг гаргаж, актлах хөрөнгийн жагсаалтыг үйлдэн удирдлагад танилцуулж, хөрөнгийг актлах, холбогдох газарт хөрөнгө актлах саналыг хүргүүлсэн байна.	Г,Т
	4.Байгууллагын өмч хамгаалах зөвлөлтэй хамтран өмч хамгаалах, хадгалах, ашиглах дүрэм, журмыг боловсруулан баталгаажуулах, хэрэгжилтийг ханган ажиллах, хяналт тавих	Өмч хөрөнгө ашиглах, хадгалах хамгаалах журамтай болсон байна.	Г

4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төв заал болон багийн заалыг иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад түрээсийн гэрээгээр ашиглуулах, гэрээ байгуулах, орлогыг тооцон төвлөрүүлэх, баримтжуулах, удирдлага болон хамт олонд орлого, зарцуулалтын мэдээллээр ханган ажиллах, орлого, зарлагын мэдээллийн сан бүрдүүлсэн байх	Спорт заалаар үйлчлүүлэх иргэд аж ахуйн нэгжийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна.	Г,Т
	2.Хамтран ажиллаж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллага үйлчлүүлэгчдийн гэрээ, заалаар үйлчлүүлж буй иргэдийн бүртгэл хийгдсэн байх	Улирал тутам үйлчлүүлсэн иргэд, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл мэдээллээр нягтлан бодогч, удирдлагыг хангаж, ажилласан байна.	Г
	3.Спорт заалуудын ая тохитой тохилог, цэвэрхэн орчин бүрдэж, ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэм хангагдсан байх, цэвэрлэгээ үйлчилгээний чанар, өмч хөрөнгөд хяналт тавих	Үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байна.	Г,Т
	4.Спорт заал, багийн заалуудын ХАБЭА, галын аюулгүй байдлыг ханган ажиллах	Стандартын шаардлага хангасан байна.	Г,Т
5 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын туслах үйлчилгээний ажилтнуудын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг гаргаж, удирдлагын хурлаар батлуулан албан хаагчдын оролцоотой дүгнэж сар, улирал, хагас бүтэн жилээр дүнг нэгтгэн тайлагнах, урамшуулал олгох	Ажилтнуудын ажлын сахилга хариуцлага сайжирсан байна.	Г
	2.Байгууллагын туслах, үйлчилгээний ажилтнуудын ажлын тайланг улирал, хагас бүтэн жилээр нэгтгэх, тайлагнах, дүгнүүлэх	Туслах, үйлчилгээний ажилтнуудыг хариуцан чиг үүргээр ханган ажилласан байна.	Г
	3.Байгууллагын туслах, үйлчилгээний албан хаагчдын ажил үүргийн хуваарийг гаргаж, удирдлагаар хянуулах, хяналт тавих	Ажилтнуудыг удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан байна.	Г
	4.Багийн заал зохион байгуулагчдын орлогыг тооцох, нягтлан бодох бүртгэл хөтлөх журмын дагуу баримтжуулах, заалаар үйлчлүүлсэн иргэдийг бүртгэлжүүлж, архивын баримт бүрдүүлсэн байх, удирдлага, нягтлан бодогчийг мэдээллээр	Байгууллагын орлого бүрдүүлэлтийн хяналт сайжирсан байна.	Г,Т

	хангах		
6 дугаар зорилтын хүрээнд	1.Няравын ажлын төлөвлөгөөг улирал, хагас, бүтэн жилээр боловсруулж батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах	Ажлын байрны чиг үүргийг ханган төлөвлөсөн байна.	Г,Т
